

Батлав:.....



О.Мөнхбат /Оюутны алба, хамтын
ажиллагаа хариуцсан дэд захирал/

ХӨТӨЛБӨР СУРГАЛЧЛАХ ӨДӨРЛӨГИЙН УДИРДАМЖ

1. Өдөрлөгийн зорилго:

Мэргэжлийн хөтөлбөрийн тухай танилцуулга хийж, мэргэжил сонголтын сурталчилгаа, мэргэжил сонгох оюутанд зөвлөгөө, мэдээлэл өгнө. Мэргэжлийн тэнхим, бүрэлдэхүүн сургуулиуд зэрэг олгох хөтөлбөрөө танилцуулснаар мэргэжил, шинжлэх ухаанаа сурталчлах боломжтой.

2. Өдөрлөг зохион байгуулах үйл ажиллагаа

Өдөрлөгийг сургуулийн захирал, дэд захирал, тэнхимийн эрхлэгч, оюутны алба, сургалтын нэгдсэн алба, бүрэлдэхүүний сургалтын албад хариуцан бүрэлдэхүүн сургуулийн товлосон хугацаанд оюутны албанаас гаргасан удирдамжийн дагуу зохион байгуулж, оюутны албанд тайлангаа 12 сарын 28-нд өгнө. Тайланд:

- Хөтөлбөр сурталчлах өдөрлөгийг хэрхэн хийж гүйцэтгэсэн талаарх товч мэдээ
- Өдөрлөгт хамрагдсан багш, оюутны тоо. Хавсралт (Мэргэжил сонгох оюутнуудад зориулан тэнхимээс гаргасан гарын авлага, тараах материалыг хавсаргах, өдөрлөгийн үеэр тулгарсан хүндрэл бэрхшээл, тэдгээрийг зохицуулах арга зам, цаашид хөтөлбөрийн сайжруулахад чиглэсэн санал зөвлөгөө, зураг хавсаргах

2.1. Зохион байгуулах нэгж

Мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулгыг Оюутны алба нь, СНА, бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба, харьяалах тэнхим, хөтөлбөрийн зөвлөх багш нартай хамтран зохион байгуулна. Холбогдох нэгжүүд дор дурдсан үйл ажиллагааг хариуцан гүйцэтгэнэ. Үүнд:

Оюутны алба:

- Мэргэжлийн хөтөлбөр танилцуулах удирдамж боловсруулах
- Мэргэжлийн хөтөлбөрийн нэгдсэн хуваарийг бүрэлдэхүүн сургуулиудын саналд үндэслэн боловсруулж, мэдээллийг нийтэд хүргэх ажлыг зохион байгуулах
- Хөтөлбөр сурталчлахтай холбоотой сурталчилгааны хуудас, мэдээллийн тоймыг

бэлдэх, хэвлэх, түгээн тараах

- Өдөрлөгт хамрагдсан оюутнуудаас санал асуулга авах
- Тайланг нэгтгэн мэдээ бэлтгэх

Сургалтын нэгдсэн алба:

- Хөтөлбөр сонголтын тараах материал боловсруулах
- Хөтөлбөр сонголтын шторк хийх
- Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн (бүрэлдэхүүн сургуулиудын хөтөлбөр хариуцсан мэргэжилтний ажиллах хуваарийг гаргах)

Бүрэлдэхүүн сургуулийн сургалтын алба:

- Мэргэжлийн хөтөлбөр сурталчлах өдөрлөгийн саналыг тэнхимүүдээс авах
- Өдөрлөг болох анги танхим, техник хэрэгслээр хангах
- Хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн мэргэжлийн хөтөлбөр сонгох журам танилцуулах

Мэргэжлийн хөтөлбөр сурталчлах тэнхим:

- Мэргэжлийн тэнхимийн товч танилцуулга
- Тухайн хөтөлбөрөөр суралцах оюутанд олгох мэдлэг, ур чадвар, мэргэжилтний ажлын байрны эрэлт хэрэгцээ зэрэг мэргэжлийн хөтөлбөрийн талаарх танилцуулга
- Тэнхимийн багш нарын заах арга зүйн онцлог, давуу талыг харуулсан материал

Хөтөлбөрийн зөвлөх багш:

- Сургалтын үйл ажиллагаа, хөтөлбөртэй холбоотой зөвлөгөө өгөх.

2.2. Өдөрлөг зохион байгуулах хугацаа

Мэргэжлийн хөтөлбөрийг сурталчлах өдөрлөгийн товыг бүрэлдэхүүний сургалтын албанаас гаргах ба 11 сарын 25-нд оюутны албанд ирүүлнэ. Өдөрлөгийг 2016 оны 12-р сарын 1-нээс 12-р сарын 25-ны дотор багтаан зохион байгуулна.


2.3. Өдөрлөгийн үндсэн үйл ажиллагаа

Мэргэжлийн хөтөлбөрийг сурталчлах өдөрлөг

Оюутанд мэргэжил сонгоход нь чиг баримжаа олгож, сонголтоо хүсэл зорилго, чадвартаа нийцүүлэн ухамсартай, мэдээлэлтэй хийх, ажил олгогчид, тухайн хөтөлбөрийг сонгосноор олж авах мэдлэг, ур чадварын талаар, мөн оюутнуудын дунд зохион байгуулдаг олимпиад, уралдаан тэмцээний талаар мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулна. Үйл ажиллагааны дараалал:

1. Мэргэжлийн хөтөлбөрийн танилцуулга

2. Тэнхимийн хамт олныг танилцуулга
3. Тухайн мэргэжил, шинжлэх ухааны чиглэлээрх Олимпиад, хурал, уралдаан тэмцээний танилцуулга

Боловсруулсан  Ж.Бадамханд

Оюутны алба

2016.11.14